

ШАШИН ТӨРИЙГ ХОСЛОН БАРИГЧ АНХДУГААР БОГД ЖАБЗАНДАМБЫН ТӨР ШАШНЫ БОДЛОГО

Дугарсүрэнгийн Энхцэцэг

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Анхдугаар Богд Жибзандамба хутагт тавь орчим жил Монголын төрийг барьж төр ёсыг бэхжүүлэх, тусгаар тогтнолоо хамгаалан, улс орны нийгэм, соёл, оюун санааны амьдралд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн "Монгол төрийн тэргүүн" төр шашныг хослон барьсан их хаан байсан.

Түлхүүр үг: Монгол улсын Төр шашны тэргүүн, эв нэгдэл, энх амгалан, Цагийг тохинуулагч залбирал, Соёмбо

XVI зууны эцсээр Халх Монголын *Сэцэн хан*, *Түшээт хан*, *Засагт хан* аймгийн ноёд Өмнөд Монгол дахь хэрэг явдлыг хөндлөнгөөс ажиглан, Лигдэн хааны цэрэг-улс төрийн бодлогын талаар харилцан адилгүй байр суурь баримталж байв. Халхын ноёдын олонхи нь Манжийг эсэргүүцсэн Лигдэн хааны үйл ажиллагааг дэмжсэнгүй, төдийгүй түүнийг Халхын нутагт орж ирэхээс болгоомжлон зарим ноёд "цэргийн тусламж хүсэх", "галт зэвсгээр туслана уу?" гэж Хаант ороост элч¹ зарах болжээ. 1634 онд Лигдэн хаан тэнгэрт хальж, Өмнөд Монгол манжийн захиргаанд орсноор, Халх Монголын улс төрийн үүрэг улам бүр нэмэгдэн, тусгаар тогтнолоо хадгалах, их хааны удам угсааг Халхад шилжүүлэн, Алтан урагтны төрт ёсыг Халхаар төвлөн уламжлуулахыг чармайж байв. Монголын их хааны хаан ширээг залгамжлах Эжи Хонгорыг эх Наннан тайху албат харьяат нарынх нь хамт авчирах "Заллагын бичиг" болон Монгол хаадын төр ёсон Халхын нутагт шилжин буй тухай Манжийн хаанд тусгайлан бичиг уламжилжээ. Үүнд: "...Олноо өргөгдсөн Маха Самади Сэцэн хааны зарилаг, Тайху эрх хүүхэн Зэлмэ дархан ноён тэргүүлэн хэдэн зайсангуудад бичиг, өгөв...төрийн самуунд нааш цааш эс явалцлаа. Бид тустан үг гэмгүй өшөө хясаа үгүй билээ. **Хаан дээд төрөлдөө өөд болж, та бүгдийг асуй гэхийг сонсож, ...Ханд төрөл билээ. Харцаст эзэн билээ, саадгүй ирэлтэй байнам** ...Тайху мань хатанд охин дүү билээ ...төрөөр ч төрснөөр ч шадар минь билээ..."² хэмээн хаан төрийн залгамжлалыг Монголын голомт нутагт авчрах, Манжийн гарт орохоос сэргийлэн болгоомжилж байжээ.

Нөгөө бичигт "...Маха Самади Сэцэн хаан. Түшээт хаан Сэцэн жонон эхлэн их бага ноёд. Усны жаран гурван омогтны эзэн болсон Сэцэн хаанд бичиг өргөн барив. Бичиг барихын учир. Хан хүнд хас их төр хамагт сонсогдох сайн алдар нар хэрэгтэйн тулд. Хамгаас төр шашныг мандуулах нэрийг эрэлтэй. Зургаан түмний эзэн биднийг жолоодож эс чадав. Тэр эс чадавч хан төрөлт бидний өөргүйн тулд **хас их төрийг хадгалж суунам бид**. Энэ их төрийг санахул нь нааш цааш элч юугаан тасралтгүй мэнд асуулцан явъя. Ийн хийж явахул эрдэнэт хүний төрөл олж, эрх хүчит хан болон төрсний гавъяа бидний тэр ажаамуу гэж айлтганам ..."³ хэмээн Монголын их хааны хас их төр ёсон үл тасран, Халхын нутагт шилжин хадгалагдан буй тул Манж, Монгол хоёр улс элч солилцон, хоёр улс эв найртай зэрэгцэн оршихийг сануулжээ.

Гэвч Халхын ноёд хааны үр садыг нутагтаа авчрах явдал бүтэлгүй болж Заллагын бичиг Манж хааны гарт орж (1635.VII.11), Ордосын бошгот жонон Эжи хонгор нэрт

¹ Материалы по истории русско-монгольских отношений .1636-1654. Сборник документов.М.,1874. с.41
Шастина Н.П.Русско-Монгольские посольские отношения XVII века.М.,1954.с.26,91,

² XVII зууны тэргүүн хагасын Монгол Манжийн харилцааны түүхэнд холбогдох баримт бичгүүд. (эмхэтгэсэн Нямка., Ли Бао-Вень). УБ, 2004 ,тал .27,52

³ XVII зууны тэргүүн хагасын Монгол Манжийн харилцааны түүхэнд холбогдох баримт бичгүүд. (эмхэтгэсэн Нямка., Ли Бао-Вень). УБ, 2004 ,тал.28,53

хааны хөвгүүнийг, Сутай тайху эх, харъяат олных нь хамт зайлуулан авахыг оролдсон ч манжийн цэрэгт гүйцэгдэн Хатан голын Толитид 1000 илүү өрхийн хамт хүчинд автан манжид булаагджээ. Ордосын Шар зүрх нэрт газар Манжийн хааны илгээсэн Түргэн, Сахалиян жанжидын цэрэг Лигдэн хааны их хатан Наннан тайхуг /хүү нь Абуни чин ван Д.Э/ хүн ардын хамт эрхшээн авч, Манжийн сэцэн хаан Лигдэний хатад, хөвгүүдийг ивээлдээ авсан дүр үзүүлж, өөрийгөө Монголын хаан ширээг залгамжлагч хэмээн нийт монголчуудыг өөртөө таатах эчнээ бодлого агуулж” тэнгэр хайрлаж, зургаан улсын эзнийг эхлэн бүгдийг тэнгэр надад соёрхсон”⁴ гэж байсан.

Энэ үед халхын ноёдоос хамгийн нэр нөлөө бүхий Шолой сэцэн хаан 1636 оны I сард Манжийн хаанд элч илгээн “...Хас их төрийг энд төр нааш цааш тасралтгүй мэнд юугаан асуулцаж төрийн хадаас шашны наран болж эе нэр хоёр ыг эвдрэлдгүй сахилдая шажныг наран мэт мандуулхул төрсний гавъяа ...энэ үгийг ...зөв гэхүл”⁵ гэж нэгэнт их хааны үр удамыг Халхын нутагт авчирч чадаагүй ч Монгол төрийн үндэс үл тасран Шолой тэргүүтэй Халхын ноёд төр-шашныг бадруулан сахиж буй тул хоёр тал харилцан найртай харилцаа гэж өөрийн элч, Өмнөд монголоос ирж суусан Үзэмчний Сэцэн жонон, Сөнөдийн баатар жонон, Хуучидын Илдэн түшээт, Авгын Засагт жонон их бага ноёдын олон элчийг бэлэг сэлтийн хамт илгээн хоёр улс нэн сацуу гэдгийг илтгэж, Халхын ноёд Манжийн эрх баригчидтай найрсаг харилцах замаар ирэх аюулыг сааруулахыг оролдож байв. 1637 онд Манжийн Абахай хаан хариу бэлэг сэлт бүхий элч илгээн элдэв аргаар эелдэн татах бодлого баримталж, “хоёр улс бие биеийг хүндлэн найртай харилцах”⁶ гэсэн уг захидалын утгийг мушгиж, Манжийн хаан, Халхын ноёдыг дагаж орохыг санал болгон, Манжийг түшсэн ноёдыг шагнан сайшааж⁷, эс дагагсадыг буруушаан зэмлэж, Халхын дотоод хэрэгт ололцох, эе эвийг задлахыг эрмэлзэх болов.

Тархай бутархай байдлыг гэтлэн давах, үндэснийхээ эв нэгдлийг бэхжүүлэхийг алсын хараатай улс төрийн зүтгэлтнүүд ухамсарлан, эртний уламжлалт бурхны шашныг ашиглах, өөрийн гадаад гол түшиг тулгуураа Түвэд гэж үзэж байв. Лигдэн хаан таалал төгсч, Өмнөд монгол Манжид эзлэгдэн, Халхын хязгаар нутагт Оросын түрэмгийлэл идэвхижин, Түвэдэд шашин улс төрийн бүлэглэлүүдийн зөрчил хурцдан, тэр тэмцэлдээ Монгол ноёдыг татан оролцуулахыг эрмэлзэх болсон зэрэг олон хэрэг явдлууд Халхын ноёдод үндэстнийхээ хувь заяанд илүү их санаа тавих, дотооддоо эе эвээ хичээж, гадаад харилцаанд цэрэг дайны гэхээсээ илүүтэй, дипломат аргаар тусгаар тогтнолоо хамгаалах, бэхжүүлэх бодлого баримтлахыг зүй ёсоор шаардаж байв.

Халхын ноёд эрт үеэс удаа дараа чуулган чуулж, улс төр, нийгмийн амьдралыг хуулиар зохицуулах, дотоодын эвдрэл хямралын үүдийг хааж, төрийн нэгдлийг бататгах, хамгаалах уламжлалтай байсан. Тухайлбал, 1581-1620-иод онд Халхын ноёдын удаа дараагийн чуулганаар хэлэлцэн баталсан хуулинд “Хан хүн өөр зуураа хэрэлдвэл зуун адуу, арван тэмээ ав... Отго бүгдээр зөвлөлгүй салж отголбол хошууг хоёр элчээр хураагаад ... их чуулганы болзоонд гурав хоног эс ирвээс арван адуу нэг тэмээ ав... Огт эс ирвээс зуун адуу, арван тэмээ ав... Ноёд биеэ алалцваас хар биеийг

⁴ Чин улсын дотоод нэрийн бичгийн яамны Монгол данс эвхмэлийн эмхэтгэл. Эмхэтгэсэн Чимэддорж ...нар. I .боть. ӨМАХХ., 2004. тал 255

⁵ XVII зууны тэргүүн хагасын Монгол Манжийн харилцааны түүхэнд холбогдох баримт бичгүүд (эмхэтгэсэн Нямка., Ли Бао-Вень). УБ, 2004, тал 26, 51

⁶ Халхын заагт хан Субади д илгээсэн Дайчин гүрний Тайцзун хааны гурван бичгийн тухай илтгэл (Боржигдой Оюунбилэг. БНХАУ УУБ., 2007

⁷ Дээд эрдэмт хаанаас дагаар ирэх монголчуудад хишиг хүртээлийг ихээр соёрхохыг зарласан зарилаг. /1640 он/, Хятадад орсон монголчуудыг Дайчин улсад элсэн дагуулах зарилаг. /1641 он/, Сөнөдийн ноён тэнгисийг төрийн мэргэн жүн ван өргөмжилсөн ухуулах өргөмжлөл. /1641 он/, Чин улсад дагаар ирсэн нэрсийн тэмдэглэл /1643 он/, Хуучидын Болдод, Үзэмчний Сэрэн, Авгын Дорж нар олноо авч дагаар ирсэн төрийн ноён өргөмжилсөн соёрхох өргөмжлөл /1646 он/ зэрэг олон баримт бий. Чин улсын дотоод нэрийн бичгийн яамны Монгол данс эвхмэлийн эмхэтгэл. Эмхэтгэсэн Чимэддорж нар. I .боть. ӨМАХХ., 2004. тал 278, 309-312

нь хөнөөж орхив. Хамаг улсыг нь авч хураая...алив ноёд өөр зуураа эвдэрвээс ...”⁸ гэж өөр зуурын зөрчлийг цаазлан хориглох, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх,” Эд бүгд ноёд эе нэгдэв. Энэ зедээн эс оролцвоос тусдаан явах болов”⁹ гэж зөвшил чуулган аливаа асуудлыг шийдэх хамгийн зөв арга болохыг заасан уламжлалыг баримталж байв.

Халхын дотоод эв нэгдлийг бэхжүүлэх төдийгүй баруун, зүүн монголын хоорондын аливаа маргаантай хэрэг явдлыг эв зүйгээр зохицуулахийг чармайн, улс төрийн мандлайллыг Халхын ноёд өөрийн гарт төвлөрүүлэхийг эрмэлзэх болсон. **Улс орны өмнө тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэхэд юуны өмнө оюун санааны хүрээнд эв нэгдлээ шүтэн барилдуулах нь онцгой ач холбогдолтой** болж, “...Монголчууд Буддын шашин...соёлын хүрээнд татагдан орж, бурхны шашин ноёрхох байр суурьтай болж байсан тул ...тэргүүлсэн хутагтыг ...Халхаас тодруулах ...Монгол-Түвэдийн харилцаанд идэвхитэй оролцохыг чухалд үзэж” өмнөх үеийн шашин төрийн амжилттай бодлогыг шинэ нөхцөлд бүтээлчээр үргэжлүүлжээ.

1635 онд Шолой Сэцэн Алтан ургийнхны дотроос олонд нэр хүндтэй Түшээт хан Гомбодоржийн шинэ төрсөн хүүг Халхын шашин (төрийн) тэргүүнээр өргөмжлөхөөр зөвлөлдөн өөрийн “Гэгээн” цолоо өгч, 1639 онд Ширээ цагаан нуурт Занабазарыг Халхын шашины тэргүүнээр өргөмжилсөн. Занабазар Монгол даяар Анхдугаар Богд (Энэтхэг, Түвэдэд шашин-төрийн тэргүүн Монголоор Хаан гэсэн утгатай үг-Д.Э) Жибзундамба гэж алдаршжээ. Энэ үйл явдал “улс төрийн ихээхэн учир утгатай сонголт” байж, Халх, улмаар нийт Монголыг шашны тугийн дор нэгтгэх оролдлогын эхлэл болов. Судлаач Д.Дашбадрах “...Халхын Бурханы шашны тэргүүнийг Түшээт хан Гомбодоржийн гэр бүлээс тодруулахаар Халх, Ойрадын ноёд үндсэндээ тохиролцчихсон байсан...Чингисийн угсааны нөлөө бүхий хөвгүүн тул Монголын гал голомт болсон, төр ёсны түүхэн уламжлал бүхий Халх Монголын байр суурийг өргөх, түүний өвөг эцэг Абтай сайн хан /1544-1588/ Халхад Бурханы шашныг санаачлан дэлгэрүүлсэн ...Эрдэнэ зуу хийд тэр үеийн Монголын улс төр, шашин-соёл, аж ахуйн чухал нэг болсон, Түшээт хан Гомбодоржийн хатан Ханджамц Ойрадын нөлөө бүхий ноён Далай тайшийн охин тул зээ хөвгүүнийг нь Халхын бурхны шашны тэргүүнээр өргөмжлөхөд Ойрадын ноёд, хутагт лам нарын зүгээс ...дэмжих талтай зэргийг харгалзан үзсэн буй за...дотооддоо самуурч, бүлэг бүлгээрээ гадагш ойн гарсны улмаас хүч нь үлэмж тарамдсан Ойрадын ...ноёд... Халхтай харилцаагаа сайжруулж, эв найрамдалтай байх нь ашигтай тул Далай тайшийн зээ хөвгүүнийг шашны тэргүүн байхыг дэмжсэн ...Тархай бутархай байдлаа гэтлэн давж, үндэсний эв нэгдлээ бэхжүүлэх, хамтын чармайлтаар төрийн тусгаар тогтнолоо батлан хамгаалах нийтлэг эрх ашиг зүүн, баруун Монголын хувьд нэн тэргүүнд тавигдаж байсан бололтой”¹⁰ гэж оновчтой дүгнэжээ.

Ороо бусгаа цагийн төвөргөөнт он жилүүдэд үе үеийн Монгол хаад өвөрмөц шинжтэй төрийн бодлого явуулсаар ирсэн Монгол улсын нэгэн үеийн их хаан, төр-шашны хамгийн нөлөөтэй түүхэн зүтгэлтэн бол Халхын анхдугаар Богд Жибзундамба хутагт, Өндөр гэгээн Занабазар (1635-1723) байсан. Түүнийг шашны тэргүүн, нэрт соён гэгээрүүлэгч, урлаг соёлын хосгүй зүтгэлтэн болох талаас нь анхааран судалж алдаршуулж ирсэн. Харин тухайн үеийн түүхэн цаг үе улс төрийн нөхцөл байдал түүнийг **Монгол төр-шашны тэргүүн** болгон дэвшүүлж, монголчуудын тусгаар тогтнолын талаар өвөрмөц төрийн бодлого явуулж байсан ч судалгаа харьцангуй бага, шашны бодлогоор бүрхэгдүүлсэн байх нь олонтой. Түүний намтар түүхнээ

⁸ Х.Пэрлээ. Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. УБ., 1974. Халхын үйсэн дээр бичсэн цааз. Монгол төр эрхзүйн түүх. I дэвтэр. эмхэтгэсэн Б.Баярсайхан. УБ., 2006. тал 23-37

⁹ Х.Пэрлээ. Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. УБ., 1974. Халхын үйсэн дээр бичсэн цааз. Монгол төр эрх зүйн түүх. I дэвтэр. эмхэтгэсэн Б.Баярсайхан. УБ., 2006. тал 23-37

¹⁰ Д.Дашбадрах. Монгол-Түвэдийн улс төр шашны харилцаа. УБ., 1978. тал 45-46

холбогдох сурвалж хэрэглэгдхүүн ихэвчлэн шашин суртханууны үзлийг баримталсан, "Гэгээнтэн", шашин номын их зүтгэлтэн, хуврага болох талаас тэмдэглэж¹¹, манжийн түүх сурвалжид Монгол улсын тусгаар тогтнолыг үгүйсгэх, монгол хаадын удам угсааг аль болох бүрхэгдүүлэх зорилгоор Занабазарыг шашны зүтгэлтэн болохыг түлхүү тусгасан, өнгөрсөн тогтолцооны үеийн түүх бичлэгт марксизм зонхилж, аливаа шашны холбогдолтой асуудлыг илт эсэргүүцэх, түүний үйл ажиллагаа түүхэн үүргийг мушгин гуйвуулж байсан зэргээс шалтгаалдаг. Мөн Монголын хаант засаг төр сулран доройтон "хаан билэгдлийн шинжтэй" гүйцэтгэх засаглал эрх хэмжээ нэмэгдэн, цэрэг улс төрийн олон үйл явдлаараа Чахундорж, Галданбошгот нарын үйл ажиллагаа идэвхитэй байсан нь түүний түүхэн үүрэг, улс төрийн үйл ажиллагааг бүрхэгдүүлэх бас нэг шалтгаан болжээ. Иймээс *Занабазарын нийгэм улс төрийн салбарт гүйцэтгэсэн үүргийг судлахад анхаарал хандуулахад "Монгол улс", "хаан", "төрийн тэргүүн", "тусгаар тогтнол", "шашин-төр" зэрэг олон асуудлууд бие биеэ нөхвөрлөн судалгааг тодруулах болно. Өгүүлэгдэн буй үед аливаа улс оршин тогтнож буй нь Хаант засаг төр бөгөөд хаан нь туурга тусгаар улс болохыг илэрхийлдэг. Иймээс Занабазар "Монгол төрийн тэргүүн, төр шашныг хослон барьсан их хаан" мөн. Тэрээр тавь орчим жил монголын төрийг барьж төр ёсийг бэхжүүлэх, тусгаар тогтнолоо хамгаалах, монголчуудын соёл, нийгэм, оюун санааны амьдралд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн билээ.*

Тухайн үеийн Монгол улсын гадаад дотоод байдалтай холбон авч үзвэл Лигдэн хаан нас барснаар, улс гүрэн мөхсөнгүй, улс орон оршин тогтнож буйг илтгэн Занабазарыг хаан өргөмжилсөн нь санамсаргүй хэрэг байсангүй. Юуны өмнө хааныг Алтан урагтны дотроос өргөмжилдөг уламжлалыг баримталжээ. Түвэд, Монгол хэлээр бичигдсэн хутагт хувилгаадын намтарт тэр бүр дурьддаггүй атал Занабазарын намтарт Тэнгэрийн хөвүүн Чингисийн Алтан ургийн угсаа залгамжлалыг үе улиран тодорхой өгүүлж, жирийн нэгэн шашны зүтгэлтэн бус **хаан** болохыг нь тодотгожээ. Зая Бандидагийн Анхдугаар богдын намтарт "Хүчний хүрдийг эргүүлэгч, эсрэн тэнгэр Чингис хаанаас 27 үе Батмөнх Даян хаан, түүний 11 аги байсны 10 нь Жалайр хунтайж, түүний долоон агийн гутгаар Үйзэн ноён, түүний зургаан аги байсны ууган нь Авдай нэрт хаан ...түүний аги Эрхий мэргэн, түүний аги Очир түшээт хаан хэмээх шашин төр хоёрыг аугаа ихээр болгон үйлдэгч энэхүү Богдын эцэг мөн..."¹² Дагважанцангийн бичсэн өөр нэг намтарт "...Язгуур нь хотол төгс Чингис угсааны шашин төрийг уужим ухаан ид заль чин зоригоор тэтгэгч хан Гомбодоржийн хүү..."¹³ гэх зэргээр бусад намтарууд, Галдан туслагчийн "Эрдэнийн эрих" зэрэг сурвалжид уг гарлыг нэн тодорхой тоочин өгүүлсэн нь Алтан урагтны хойчис, төрийн дээд эзэн, их хааныг нийтээр хүлээн зөвшөөрөх ёс, хууль ёсны засаглалын уламжлалтай холбоотой

Хамрал тэмцэл ужигран, улс орон сулран, хаант төр ганхсан тэр л цаг үед эв нэгдэл, тусгаар тогтнолын билэгдэл гэдэг утгаар шашин номын ёсоор нэр хүндийг нь өргөх зорилгоор шашин төрийн уламжлалыг баримтлан цаг үеийн нөхцөл, хүчин зүйлд зохицуулан **Занабазарыг төр шашныг хослон барих хаанд өргөмжилсөн** нь хоёр ёсны сургаалийг хүндэтгэн дагасан хэрэг болно Төрийн дээд эрхийг хаан хүмүүн барьдаг оронд Хаан хуулиа тогтоодог, хуулийн дагуу улс орноо удирддаг, хууль зөрчигсөдийг ял шийтгэлийг ч хүлээлгэдэг цорын ганц дээд эзэн байдаг. Нэг хүний гарт засаглалын бүхий л эрхийг төвлөрүүлсэн тул Хаант засаг бурхан тэнгэрээс заяасан хувь төөрөгтэй гэсэн төр шашны хууль эрт үеэс Монголд уламжлан ирсэн

¹¹ Монгол түвэд хэлний сурвалжуудад түүнийг төр-шашныг төвшитгөсөн гэж бичдэг ихэвчлэн, шашин, соёлын үйл ажиллагааг дурьсан байдаг.

¹² Зая Бандида. Жибзундамда Лувсандамбижалцанбалсанбогийн ердийн товч намтар түвэд хэлнээс орчуулж тайлбар хийсэн. Ш.Бира /Өндөр гэгээний намтар оршивой/ УБ., 1975. тал .7-8

¹³ Дагважанцан. Тийн удирдагч Жибзундамба их эрдэнийн намтар магтаалын үг сайн хувьтны сүсгийг сэргээгч оршшвой. түвэд хэлнээс орчуулж, тайлбар хийсэн. Ш.Сонинбаяр /Өндөр Гэгээний намтар оршивой/ УБ., 1995. тал 4

Энэ уламжлал хөгжсөөр Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазары үед **"Төократ засаглал"** албан ёсоор тогтжээ. Дэлхийн бусад томоохон шашинтай харьцуулбал "Буддын шашин нь төр нийгмийн амьдралыг тогтвортой, нягтрал, нэгдэлтэй болгогч хүчин зүйлс байсаар ирсэн...төрийн эрх мэдэл, засаглал, өмч хөрөнгө, эд баялаг тэдгээрийн төлөөх шунал, хүсэл, тэмцлийг биш харин сэтгэл санааны болон үйл хөдлөлийн тайван амирлангуй, хүлцэнгүй байдал, оюун ухааны гэгээрэл бясалгал, зөв зам мөр, буян сайн үйлийг эрхэмлэж ирсэн" түүхтэй тул Анхдугаар Богд Жибзундамбын амьдрал үйл ажиллагаа урьдах хаадын үйл хэргийг уламжлан, улс монголынхоо тусгаар тогтнол, хөгжил дэвшил сайн сайхны төлөө зүтгэж байжээ. Анхдугаар Богд Жибзундамбын хувьд Түвэд, монгол даяр нөлөө байр суурь нь нэмэгдэж буй V Далай лам, Банчин Эрдэнэ нартай харилцан, Халх дахь Бурханы шашны уламжлалт улааны урсгалыг баримтлахаас илүүтэй Жонанба ёс улмаар Гэлүмбагийн ёсыг баримтлах болсон нь тухайн үеийн улс төрийн амьдрал, монголчуудын нийтлэг эрх ашигтай холбоотой байжээ.

1640 онд Тарвагатайн Улаан бураад Халх-Ойрадын ноёд чуулж, эв зээ нэгтгэж, харийн түрэмгийлэлээс тусгаар тогтнолоо хамгаалах үзэл санаа шингэсэн "Их цааз"-ыг хэлэлцэн баталсан байна. Энэ цаазын эхэнд **"Очир дар лам**, Шакямуни, Богд Зонхов, Далай лам, Банчин Эрдэнэ тэргүүтэнд залбиран мөргөмүй"¹⁴ хэмээн эхэлдэг нь нийт Монголыг шашны тугийн дор нэгтгэх зорилт тухайн үеийн гол зорилт байсныг харуулж дээр дурьдсан Богд гэгээнийг улс орны эрхэм дээд төр-шашныг хослон барьсан хаан өргөмжилсөнтэй нягт холбоотой юм. Хэдийгээр нас бага ч монгол талаасаа хамгийн гол хүн болохыг илтгэсэн анхны баримт бөгөөд улс төрийн амьдралд оролцож эхэлсэн анхны баримт болж, Богд Жибзундумбыг Халхын төдийгүй нийт Монголын шашин-төрийн тэргүүн гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх зорилгыг Түшээт хан тэргүүтэй ноёд баримталж байв. "Төмөр луу жилийн намрын дунд сарын арван таванд (1640.IX.20) Эрдэнэ засагт эхлэн Түшээт хан, Убаши далай ноён, Далай хун ноён, Цэцэн ноён, Илдэн ноён, Мэргэн ноён, Эрдэнэ хун тайж, ...Эрдэнэбаатар хун тайж, Хөндлөн убаши, Гүүш номын хан, Өрлөг, Шүхэр дайчин ...дечин дөрвөн хоёрын их ноёд **"чуулган чуулж, цааз хэлэлцэн "Аливаа хүн энэ их төрийг эвдэн, их аймаг улсыг алж талж авбаас Монгол Ойрад хоёр нэгдээд"**"¹⁵ улс орны эв нэгдэл, тусгаар байдлыг хамгаалан бэхжүүлэхийн чухлыг хуульчлан тогтоосон нь "тухайн үеийн Монголын нийгмийн ухамсарт гарсан дэвшилтэт үзэгдэл" болжээ¹⁶ гэж академич Ш.Бира дүгнэжээ. Ширээ цагаан нуур, Улаан бураагийн чуулган хоёр монголчуудын улс төрийн амьдралд чухал ач холбогдолтой, хоорондоо учир шалтгаан бүхий нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлсэн түүхэн үйл явдлууд байж, улс орны аливаа асуудлыг чуулган, зөвшлийн замаар хэрэгжүүлж, сөргөлдөөн, зөрчил үүсэхээс сэргийлэх нь **"Төр улс амгалан оршихийн баталгаа"** гэж үзэж ирсэн Монгол ноёдын улс төрийн оновчтой бодлогын үргэлжлэл, үр дүн байсан гэж хэлж болно. "Халх, Ойрадын төр шашны нөлөө бүхий зүтгэлтнүүд, Хөх нуурын монголчууд, Ижил мөрний торгуудын төлөөлөгчид"-ийн оролцсон чуулган улс төрийн бутралыг давж, үндэсний нэгдлийг сэргээн бэхжүүлж, зөрчил үүсэхээс сэргийлэх, харийн дайсны өнгөлзлөгийг устгахад монголын олон аймгийг хамтын чармайлтыг зохион байгуулахад чиглэгдэж байв. Манжийн Эебээр заагч хаан 1644 онд Түшээт ханд, 1645 оны эхээр Маха Самади Сэцэн хаанд " ...Эдүгэ их улсыг амаржуулахын тулд төрийн эебээн нэгтгүүлэх хэрэгтэй буюу "¹⁷ гэх утга бүхий бичиг захидал

¹⁴ Монголын улсын арван буянт номын цагаан түүх нэрт судар оршвой. Монгол төр эрхзүйн түүх. I дэвтэр эмхэтгэсэн Б.Баярсайхан.УБ., 2006 тал 38

¹⁵ Монгол улсын арван буянт номын цагаан түүх нэрт судар оршвой. Монгол төр эрхзүйн түүх. I дэвтэр эмхэтгэсэн Б.Баярсайхан.УБ.,2006 тал 38

¹⁶ Ш.Бира. Монголын түүх соёл,түүх бичлэгийн судалгаа Токио.1995 тал 81

¹⁷ Чин улсын дотоод нэрийн бичгийн яамны Монгол данс эвхмэлийн эмхэтгэл. Эмхэтгэсэн Чимэддорж ...нар. II.боть.ӨМАХХ.,2004 тал 56

уламжилан монголчуудыг дорд үзэн, дайрч, басамжилсан үг огт үгүй, аль болох найртай харилцахыг чармайсан нь эрх биш Тарвагатай чуулгантай холбоотой.

Харин Мин улсыг эзлэн авснаар, Манж эдийн засаг, цэрэг, улс төрийн талаар хүчирхэгжин, Монголчуудын нэгдмэл байдлыг задлан саринуулах, өөрийн бодлыг тулган шаардах хандлага давамгайлан, Түвэдийн шашны зүтгэлтнүүдээр дамжуулан бурханы шашны нөлөөг ихэд ашиглах болсон. 1652 онд Сэцэн хан Шолой, 1655 онд Түшээт хан Гомбодорж нар нас барсан нь Халхын дотоод байдал ээдрээтэй болж, Манжийн эсрэг хийх цэрэг улс төрийн үйл ажиллагаа саарч, дотоодын зөрчил нэмэгдэн, Халх-Ойрадын харилцаанд ч өөрчлөлт гарчээ. Энэ эгзэгтэй үед **Богд хаан шашин төрийн өвөрмөц бодлогоор улс орноо хамгаалах, хүч чадал нь өдөр ирэх тусам нэмэгдэж буй Манжийн их хүчний эсрэг сөрөн зогсоход хүрсэн.**

Богд хаан, улс орны хаант төр, шашин номын билэгдэл төдийгүй. Халх болон нийт Монголын улс төрийн амьдралд идэвхийлэн оролцож, тухайн үеийн хамгийн нэр хүндтэй улс төрийн зүтгэлтний хувьд эвдрэл хямралыг зогсоох, шашин-улс төр, оюун санааны талаар нэгтгэх талаар олон зүйлийг санаачлан хийжээ. Занабазар, Манж-Монголын зөрчил, Халхын дотоодод өрнөсөн Засагт ханы ширээний төлөө тэмцэл, Түшээт хан-Засагт ханы зөрчил, Халх-Ойрадын өрсөлдөөнийг зохицуулах, Монголын дотоод хэрэгт хүч түрэн оролцох болсон Манжийн хааны бодлого үйл ажиллагааны эсрэг уян хатан бодлого явуулж байв.

Манжийн хаан, Өндөр гэгээний хоорондоо харилцсан бичиг захидлын нилээд эртнийх болох 1647 оны Эебээр засагчаас Өндөр гэгээнд өгсөн бичгээс үзвэл Тэнгис вангийн бослого, Түшээт ханы ноёд Бааринг довтолсон зэрэг асуудлыг эв зүйгээр зохицуулах талаар өөрийн саналыг Манжийн хаанд хүргүүлж, харилцаж байсан нь тодорхой.¹⁸ 1660-аад оноос Халхын баруун гарт зөрчил үүсч, Халхыг хамарч улмаар нийт Монголын дотоодод самуун үүсснийг арилган, ноёдыг эелэлдүүлэхэд тэрээр их үүрэг гүйцэтгэж, Халх-Ойрадыг зөрчилдүүлэн салгах, улс орны дотоод хэрэгт оролцох Манжийн хааны санаархлыг хязгаарлахад өөрийн үйл ажиллагааг чиглүүлж, 1686 онд болсон Хүрэн билчирийн чуулганы өмнө, хойно, чуулганы үйл ажиллагааны үеэр тэрээр ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. 1686 оны зун Манжийн хаанд хүргэсэн Өндөр гэгээний захидалд "би өчүүхэн цагаас нааш Очир дарь Богд ламын соёрхол хийгээд дээдийн нэрд шүтэн, өөрийн тусын сэтгэлээр ч **энэ оронд шашин эрдэнийн өргөл хийгээд хаадын тэмцэл засах, харшлах зовлонг аврах тэргүүтнийг чинээн дэгээн нийлүүлэн үйлдсээр ирэв.** Энэ Халхын эвдрэлийг засахын тулд Далай ламын элч ...хоёрын хамтаар, нээдэх хувилгаан лам лугаа бие бээр зассаар ирэв. Эдүгээ бас төр шашны тусад "Далай лам, Галдан ширээтийн хамт Хүрэн билчирт чуулган /нийлэхээр/ болов ...Далай ламын сургаал зарилаг бичгийн үлэмж дор эртний монгол сайн ёс цааз судраар нийлүүлэн ...нэн халхын өөрийн эртнээс асан цааз журмаар али үнэнийг үйлдэж хамаг хаан ноёд, түшмэд сэлтэс дор сургагасан засдаг...Монголын эртний сайн ёсон хууль цааз"¹⁹ уламжлалыг баримтлан явуулах, чуулганы үеэр гол эрхийг өөрийн гарт төвлөрүүлэх зорилгоо тун тодорхой мэдэгджээ. Иймд Энх-Амгалан хаан өөрийн болон Далай ламын элчээр дамжуулан чуулганы үйл ажиллагааг саатуулахыг оролдож байв.

Хүрэн бэлчирийн чуулганд (1686.VIII.16-23) бэлтгэн Занабазар, Далай ламын элч Ширээт хутагт, Түшээт хан, Засагт хан, Цэцэн ханы хүү Арадан Илдэн тайж, Манжийн хааны элч Аранай амбан нарт өөрийн үг сургаал, албан бичгийг урьдчилан өгч, Эл аймгаас 91 түшмэлийг тангаргат түшмэл болгон оролцуулж Түшээт хан, Засагт ханыг тангаргалуулан эвлэрүүлж хэдэн хэлэлцээний яриаг 500 нуруутай (зүйл бадагтай) бичиг болгон Ширээт лам, Богд хаан, Халхын гурван хан, Манжийн элчин нар зургаан

¹⁸ Халх, Дайчин гүрэнд дагаж орохоос өмнөх Өндөр гэгээний зарим улс төрийн ажилгаанаас үнэлэх нь (Боржигдой Оюунбилэг. БНХАУ) /илтгэл/

¹⁹ Халх, Дайчин гүрэнд дагаж орохоос өмнөх Өндөр гэгээний зарим улс төрийн ажилгаанаас үнэлэх нь (Боржигдой Оюунбилэг. БНХАУ) /илтгэл/

тамга тус тус дарж, тангаргын түшмэдийг нааш, цааш явуулж хэргийг шийдвэрлэхийг оролджээ. Гэвч Галдан чуулганы үйл ажиллагааг эсэргүүцэж, Засагт хан уг шийдвэрийг хүлээн авсангүй чуулган үр дүн үгүй болов. Манай түүх сурвалжид энэ чуулганыг Манжийн хаан зохион байгуулсан гэх боловч тухайн үеийн "сурвалж баримтыг үндэслэвэл Өндөр гэгээний үүрэг их байжээ"²⁰ гэдгийг харж болно. Манж нар энэ чуулганыг тасалдуулахыг бүхий л талаар оролдож байсан нь илэрхий.

Хүрэн бэлчирийн чуулганы дараа Манж нар Халхын дотоод хэрэгт оролцох нь улам нэмэгдэн, Сэцэн ханы орийг нэр заан томилохыг хүсч, "Бид ...Халхын өвөр зуурын ...муудалцсаныг түшмэл ба лам илгээн "зохицуулсан билээ "...эдүгээ туслагч түшмэл илгээн, Сэцэн хааны орд ..Аравдан илдэнг алдарт сайн хүмүн хэмээн сонсов. Ахмад хөвгүүнийг залгамжлуулдаг ...танай Халхын ёсоор Аравдан илдэнг суулгавал зохиму та хурдан хэлэлцээд хан суулгагтун!"²¹ гэсэн адилавар утгатай захидал зарилагийг Жибзанбамба хутагт, Далай лам, Түшээт хан, Засагт хан нарт 1687 оны III сард илгээн уламжилжээ.

Үүний хариуд Жибзандамба хутагт өөрийн улс төрийн байр суурийг илтгэн, Энх-Амгалан хааны зариланг бичгийг үл ойшоон хүлээн авах боломжгүйг илэрхийлж, улс орны эрх ашгийн төлөө хэдэн санал дэвшүүлж байв. Тухайлбал, энэ Аравдан илдэн тайж эцгийн үед ч зөв төрөөс гадна авирлахуй дор хэдий зөвөөр сургаал хэлэвч сонсдоггүй асан тул хаан мэт боловоос шашин төрд ч муу болох буй хэмээн сэтгээд ...хожим бүгдийг амаржихуйд ...үлэмж муу болгужин ...олон ноёд ч түүнийг үл зөвшөөрч буй учраас Энх-Амгалан хааны саналыг хүлээн авах боломжгүй"²² гэдгээ хэлжээ. Энэ нь санал болгосон хүн нь бус, манжийн хаан халхын дотоод хэрэгт хэтэрхий дур мэдэн оролцох болсныг Занабазар хүлээн зөвшөөрөхгүй байсны илрэл юм. Мөн олон ноёд "цуглан бүгд лүгээ зөвшин али шашин тард тустай" хүмүүнийг талбих нь "жаргалангийн шалтгаан болоюу...хэмээн Сэцэн хаан болох дараалалтай нь ...Дорж Эрдэнэ цогт тайж, Дагалан мэргэн Цөхүр ..."²³ зэрэг хүмүүсийн нэрийг дэвшүүлжээ.

Өндөр гэгээн Занабазар Халх Монголын шашин-төрийн тэргүүний хувьд Манжийн хаанд өөрийн байр суурийг илэрхийлсэн "шашин төрд тус болох хамгийн зөвөөр амаржуулах сайн зариланг буулгаж" байх, "Халхын чуулганы хан ноёд...ын олонхи хүмүүсийн санаа нийлсэн хүнээр хаан болгох", "Өндөр гэгээн уг асуудлыг шийдвэрлэж байх" тодорхой саналууд²⁴-ыг илгээсэн. Энэ удааны зариланг бичиг төр шашны тусад зөв болсонгүй тул зариланг хүлээн авах боломжгүй, хүчингүй болгохыг сануулж, Халхын ноёдын чуулган дотоод аливаа асуудлаар хэлэлцэн шийдвэрлэдэг болохыг анхааруулан, манжийн зүгээс оролцохыг тайшаахгүй байгаагаа илэрхийлэхийн хамт улс оронд шашин төрийн алив асуудлыг шийдвэрлэх хууль есны эзэн өөрөө Өндөр гэгээн мөн болохыг өгүүлжээ. Энх-Амгалан хаан, Монголын дотоод хэрэгт оролцох явдлаа улам өргөтгөн, өөрийн саналыг тулган хүлээлгэх явдал газар авсаар байсан ч Өндөр гэгээн Халхын улс төрийн эрх мэдлийг хамгаалахын төлөө ихэд чармайж байсан нь илэрхий байна. "...Халхын улс төрийг худалдаж Манж Чин улсад ганц үзүүрт сэтгэлээр толгой мэхийн сөхрөн орсноор бичиж түүнийг улс төрийн талаар бүрмөсөн үгүйсгэж байсан" бол "...хэрэг дээрээ хаад ноёдын тэмцлийг эедүүлэх ...ээр өдий төдий улс төрийн арга хэмжээ авч байсан бөгөөд "Дайчин улс Халхын улс төрд

²⁰ Халх Дайчин гүрэнд дагаж орохоос өмнөх Өндөр гэгээний зарим улс төрийн ажилгаанаас үнэлэх нь Боржигдой Оюунбилэг. /илтгэл/

²¹ Халх Дайчин гүрэнд дагаж орохоос өмнөх Өндөр гэгээний зарим улс төрийн ажилгаанаас үнэлэх нь. Боржигдой Оюунбилэг. БНХАУ. /илтгэл/

²² Халх Дайчин гүрэнд дагаж орохоос өмнөх Өндөр гэгээний зарим улс төрийн ажилгаанаас үнэлэх нь. Боржигдой Оюунбилэг. БНХАУ. /илтгэл/

²³ Халх Дайчин гүрэнд дагаж орохоос өмнөх Өндөр гэгээний зарим улс төрийн ажилгаанаас үнэлэх нь. Боржигдой Оюунбилэг. БНХАУ. /илтгэл/

²⁴ Халх Дайчин гүрэнд дагаж орохоос өмнөх Өндөр гэгээний зарим улс төрийн ажилгаанаас үнэлэх нь. Боржигдой Оюунбилэг. БНХАУ. /илтгэл/

хөндлөнгөөс орж байсан байдал дор Халхын эртний цааз журмаар халхын чуулганыг засаж...улс төрийн тусгаар байдлыг...хамгаалахаар...хүчирхийллийн бус аргаар гойд уран дипломат тэмцэл хийж²⁵, “шашин-төрийг хослон барьсан, монгол төрийн-тэргүүн²⁶ байсан.

Тухайн үеийн Монголын нийгэм төр нэг талаас Манжийн түрэмгийлэл хурцадсан, Халх-Ойрадын өвөр зуураа хямралдсан үед Занабазар төр-шашны үйлийг бататгах, улс орноо амар жимэр байлгахын тулд **“Цагийг тохинуулагч залбирал” уншлага “Жанлавцогзолма”** алдарт зохиолоо 1672 оноос эхлэн туурвиж эхэлжээ. Өндөр гэгээн “хүмүүний сэтгэлийн хор, муу үйлийн үр өөртөө эргэн мэсийн хүрд болон боловсрохын цагт үүссэн, элдэв зовлонгийн галыг амирлуулж, эсэргэн тэмцэлдэхийн хонзонг арилган энэрэх асрахаар эх хөвүүн мэт сэтгэл зохилдсон буяны барилдлагад шүтэж, нэн хойтод сайныг хийж “чадью гэж үзэж...

Эсрэг тэсрэг өшөө арилан

Энэрэн асрахын сэтгэлээр найрамдаж

Энх амгалангийн өлзийг дэлгэрүүлэн соёрх!²⁷ гэж хүн болгон хүсэн мөрөөдөж байсан санааг тусгажээ. Энэ нь зэвсэгтний урьдаас зэвсэг барьж, тэмцэвч бараагүй харин хүчтэний урьдаас хүлчин тэвчихийг барьж, дотоодын самуун бүрийг найрамдуулан эелдэж чадваас, гадаадын дайсан бүгдийг дарсан лугаа адил хүчтэй байдаг гүн ухааны үзлийг дэлгэрүүлж, “үе улирсан өс хонзон, будилаан самууныг үүсгэгч шалтгаан нөхцөл, үр дагаврыг хөөн шинжилсэн “хамралыг амирлуулах-асрахуй, нигүүлсэхүй сэтгэл тэргүүтнийг үүсгэвээс цагийг тохинуулах их тустайг номложээ. Бурханы шашны нийгүүлсэнгүй сургаалын үзэл санааг төрт ёсны уламжлалтай холбож төрлийн дотор эе эв, улсын дотор эв найрамдлыг хичээх төр ёсны гол сургаалаа айлдаж хүн бүрт хүргэжээ. Шашин төрийн үйлийг ардад ойр болгохын тулд Энэтхэг, Түвэдийн шашныг Монгол “ал гаршагийн” (улаан шарын) шашин болгож авсан эртний уламжлалыг улам бүр хөгжүүлж шашин номын хурлын ая данг шинэчлэн, монгол заншил ёсыг шашны зан үйлд, шашны номын гүн утга санааг эгэл хүмүүний нүүдлийн ахуйд шилжүүлэн ихээхэн монголжуулжээ. Бурханы шашны дотоод урсгалын улаан шарын тэмцлийн алдаа оноог номын ухаанаар ялган тунгааж “хамаг бүх шашныг харшилдуулахгүй онох” сонгодог буддизмын онолыг баримтлах уламжлал, шашин төрийн хос ёсны уламжлалыг улс орныхоо төлөө номлож байсан.

Улс орны дотор оюун санаа, соёлын нэгдлийг улам бүр бататгах зорилгоор Сажийн Пагба ламын “дөрвөлжин үсэг”, харчины Аюуш гүүшийн “Али-гали үсэг”, хошуудын Заяа бандидын “тод үсэг” бүхний ололтыг багтаан монгол үсгийг төгөлдөржүүлэх, шашин төр хос ёсны хэргийг тэгш бүтээхийн тулд Занабазар номын хэлний төгс боловсорсон **Соёмбо үсгийг** 1686 онд зохион²⁸ олныг гэгээрүүлж, муу цагийн үр боловсорч харийн соёл түрэн ирэх сэтгэл амгалангүй үед Монгол улсынхаа тусгаар тонтнолын билэг тэмдэг болгожээ. Манж нар Монголыг эрхэндээ оруулах явдлыг эсэргүүцэн эртнээс уламжилж ирсэн “Бирга тэмдэг” Монгол улс мандтугай-хэмээх ном судрын эхэнд тавьдаг тэмдгээс санаа авч “Соёмбо” үсгийг зохион, тамга тэмдэг, ерөөлтэй билэгтэй ном зохиолыг энэ үсгээр бичүүлж, Манжийн ноёрхлыг далд битүүгээр эсэргүүцэн Монгол улс мөнх оршихийг бэлэгдэн хожим Монгол улсын сүлд, тусгаар тогтнолын билэг тэмдэг болжээ. Соёмбод наран саран дээр галыг гурван

²⁵ Халх, Дайчин гүрэнд дагаж орохоос өмнөх Өндөр гэгээний зарим улс төрийн ажилгаанаас үнэлэх нь. Боржигдой Оюунбилэг. БНХАУ. /илтгэл/

²⁶ Д. Энхцэцэг. Өндөр гэгээн Занабазар бол монгол төрийн тэргүүн мөн. /илтгэл/ Өндөр гэгээн Занабазарын 370 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. УБ., 2005

²⁷ Өндөр Гэгээн Занабазар. Цаг лугаа зохилдуулсан залбирал адистадын дээдийг хайрлагч оршивой. хэвлэлд бэлтгэсэн. Ш. Бира. УБ., 1995

²⁸ Дагважанцан. Тийн удирдагч Жибзундамба их эрдэнийн намтар магтаалын үг сайн хувьтны сүсгийг сэргээгч оршшвой. түвэд хэлнээс орчуулж, тайлбар хийсэн. Ш. Сонинбаяр /Өндөр гэгээний намтар оршивой/ УБ., 1995 тал. 24.

үзүүртэй дөлөөр дүрслэн, монгол хүний уг удам, гал голомт гурван цаг буюу үүрд мандан бадарч байхыг Монгол хүн бүхэн нэгэн сэтгэлээр тусгаар тогтнолоо хамгаалан дайсныг даран сөнөөхийг, хүн ард бүр их бага цөм улсынхаа төлөө шулуун шударгаар, арга билгийг хослуулан, сонор сэрэмжтэй төр түмэн хамтаар эв эеийг хичээн төмөр хэрэм мэт байвал Бидний монгол улс үүрд мандан бадрах болно гэдгийг билэгдэн зохиосон²⁹ гэж Бямбын Ренчин бичжээ. "Соёмбо тэмдэг нь эртний энэтхэгийн Намжувандан (эх болсон амьтан арван хүчийг эрхшээсэн хутаг) хэмээх ёст тэмдгээс угшиж сав ертөнцийн оршилыг бэлэгдэж шороо, гал ус, хийн дээр огторгуйг дүрслэн сав шим ертөнцөд буюу хүний тархийг тусгасан" гэж үздэг.

Он цаг улирахын хирээр улс төрийн байдал улам бүр ээдрээтэй болж, Монголчуудын зөрчил тэмцэл хурцдан биеэ биеэ мөхөөн тусгаар тогтнол алдагдах аюул нүүрлэжээ. Монголчуудын дотоод зөрчил Халх, Ойрадын хэрэг явдалын уг үндэс нь тухайн үеийн бүс нутгийн улс төрийн нөхцөл байдал Манж Чин улс, Хаант Оросын хүчирхэгжилт, "алс холын Түвэдийн төрийн хатгаасаар Бурханы шашны улаан, шашны урсгалыг улс төрд ашиглан, монголыг монголоор нь цохиулан... Манжийн эсрэг тавиж, ар хаяагаар нь Түвэдүүд Манжийн эрхшээлээс мултран тусгаар байдлаа авч гарах гэсэн ... эчнээ нууц бодлого(ос) болсон"³⁰ гэлтэй. Энэ нь хожим Галдан бошготод цэргийн ноён Данжилын хэлснээр "Чи ямагт /Түвэдийн/ Зонховын шашны талд явмуй гэсээр Өөлд долоон халхыг дуусгав"³¹, "Өчүүхэн дайсны шалтгаанаар өчнөөн улсыг дагуулан тулгар төр дагаж..."³² гэсэн Өндөр гэгээний үг зэргээс тодорхой харагдаж байна.

Ийм үед улс төрийн зөв сонголт хийх түүхэн үүрэг Занабазарт оногдож 1689 оны IX сард Өмнөд монголд Сөнид аймгийн хойд зэх Ар Элстэйд Халхын ноёдын чуулган чуулж, аймаг олны хүн ардыг сарнин бутрах аюулаас аврах, дайны хөлөөс дүрвэн тархсан халхчуудыг цуглуулан, газар нутаг хэл соёл, зан заншил, тусгаар тогтнолоо хамгаалан хадгалахын тулд түр буулт хийж, хэн нэг их гүрний ивээлд багтан улс орныхоо газар нутгийн байдлыг хэвээр хадгалах зорилгоор Орос, Манжийн ал нэгийг дагах талаар эцсийн шийдвэрийг мөн тэрээр гарган "манай долоон засгийн халх хэдүй Галданд эвдэрч цагийг мэдээд, хөвгүүн, эм, харъяат харцас албатаа хамгаалан хааныг ирж орж ирэв"³³ гэж Манжийн ивээл хамгаалалтанд орсон. Сонинбаяр ламтан Өндөр гэгээний намтруудыг үндэслэн "**Өндөр Богд хүчинд автан арга мухардан түр Манжийг түших болсноо ... Одоо Дайчин улсын эрхшээлд багтсан нь их учиртай. Жич дахин ирээдүйд умар зүгийн их гүрнийг түшвээс их тус гарна Цаг нь болохоор аяндаа ... болно цагаа болоогүй аваас дийлэхэд бэрх**" гэж айлдсыг өгүүлжээ³⁴. Нутаг ус, ард түмэн, хэл соёл үндэс язгуураа авч үлдсэн түүхэн гавъяа энэ агаад хожим түүний нэр, төр-шашны үйлсээр Монгол орон дахин тусгаар тогтносон түүхтэй тул алсын хараатай улс төрийн шийдэл байсан гэж үздэг.

Анхдугаар богд хааны Жабзандамба болон Халх монголчууд тусгаар тогтнолоо хамгаалах бодлогоо тууштай баримталж байсан ч тухайн үеийн улс төрийн байдал, хүчний харицааг зөв үнэлж, Манж нар лугаа илэрхий хүчлэн дайтан хүчинд автсангүй харин тайван замаар харьяалалд орохыг илүүд үзсэн. Энэ нь цаашдаа улс төрийн

²⁹ Б.Ренчин .Соёмба-эмблема свободы независимости монгольского народа ..Из нашего культурного наследия .УБ.,58 .стр.12-16

³⁰ Д.Дашбадрах . Монгол-Түвэдийн улс төр шашны харилцаа /XVI-XVIII зууны эхэн / .УБ.,1998

³¹ Л.Хүрэлбаатар .Өндөр Гэгээн Занабазар .Өндөр гэгээн Занабазарын 360 жилийн ойд зориулсан э/ш-ний бичиг .УБ.,1998 .тал 21

³² Л.Хүрэлбаатар .Өндөр Гэгээн Занабазар .Өндөр гэгээн Занабазарын 360 жилийн ойд зориулсан э/ш-ний бичиг .УБ.,1998 .тал 21

³³ Л.Хүрэлбаатар .Өндөр Гэгээн Занабазар .Өндөр гэгээн Занабазарын 360 жилийн ойд зориулсан э/ш-ний бичиг .УБ.,1998 .тал 21

³⁴ Ш.Сонинбаяр .Өндөр гэгээн Занабазар монголын төр ,шашин соёлд чухал шинэлэг үйлтгэл хийснийг есөн зүйлээр шинжилсэн нь . Өндөр гэгээн Занабазарын 360 жилийн ойд зориулсан э/ш-ний бичиг .УБ.,1998 .тал 129

томоохон бодлого агуулж байлаа. Манжтай илэрхий дайсагналцах нь, монголчуудад улс үндсээ устгах, аюул дагуулж, Манжид даган орох гарцаагүй нөхцөл байдалд хүргэжээ. "Аливаа улсын зүгээс бусад орныг эрхшээлдээ оруулах гэсэн түрэмгий бодлогоо хэрэгжүүлэхдээ шууд хүчээр дарангуйлах бус гадаад, дотоод байдалд нь нөлөөлж, өөрсдөө дагаар орохоос өөр аргагүй болтол нь гарцаагүй байдалд оруулах буюу "Интерференц"-д хүргэдэг. Интерференцийн түгээмэл арга нь хагалан, бутаргах, хүчийг саринуулах, хямралт байдлыг улам гүнзгийрүүлэх бодлого урт удаан хугацаанд явуулснаар тэр ард түмэн "ивээл хамгаалалтанд орох", аргагүй сэтгэл зүйн байдалд ордог³⁵ байна. Иймээс **Монголчууд Манжийн хааны ивээл хамгаалалтад багтан, бүрмөсөн устаж үгүй болох, салж тархах үндэстний мөхлийг зайлуулах замыг сонгосон нь бас Анхдугаар Богд хааны үйл ажиллагаатай холбоотой.** "Аливаа улс орны статусыг бусад улсаас хамааралтай эсэх, хамааралтай бол хэдий хэмжээний гэдгээр нь ангилан эзэмшил орон (Colony), өөртөө засах орон (Autonomy), ивээлийн орон (Protekrate), хамгаалалт болон түшмэг хараат улс (Dominign, Dependancy, Vassality), хамтын нөхөрлөлийн гишүүн улс (Intepdent Nation) гэж олон янзаар нэрлэдэг³⁶. Манжийн захиргаанд байсан Халх Монголын улс нь "Доминион" шинжийг агуулсан буюу "Defendensu"³⁷ (Хамааралтын улс) маягийн улс болсон нь хожим Өмнөд монголчуудын адил Хятадын колони болох, Ойрад монголчуудын адил салж бутрах аюулыг үл амсжээ. Энэ бүхэн Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазарын шашин төрийн бодлого үйл ажилгаатай холбоотой юм.

Abstract : The living god-the first Jibzundamba lama-Zanabazar's political and religious activities are interested by many researchers. During the second half of XVII century Mongolia's political and religious pattern was in chaos. The charismatic leader - the first Jibzundamba lama was playing a significant role in Mongolia.

Ном зүй

Монгол сурвалж

1. XVII зууны тэргүүн хагсын монгол-манжийн харилцаанд холбогдох баримт бичгүүд . эмхэтгэсэн Нямка, Ли Бао Вень (кирилл үсэгт буулгаж, тайлбар хийсэн Ц.Төрбат, Д.Энхцэцэг). УБ., 2003
2. Галдан. Эрдэнийн эрх хэмээх түүх болой Ц.Насанбалжир хэвлэлд бэлтгэв. УБ., 1960. Галдан. Эрдэнийн эрх. Ардаажав тайлбарлав. ӨМАХХ. 1999
3. Гомбоваанжил. Монгол орноо шашин төр тогтсон ёсыг сайтар өгүүлсэн тунгалаг ухаант залуусын хоолойн чимэг тунамал гэрэлт Алтан эрх монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хавсралт хийсэн Д.Бүрнээ, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал XVII. УБ., 2006
4. Жамба. Асрагч нэртийн түүх. хөрвүүлж, тайлбар зүүлт, нэрийн хэлхээ хийсэн Д.Заяабаатар. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ., 2006. Жамба. Асрагч нэртийн түүх. Оршил бичиж, хэвлэхэд бэлтгэж, тайлбар хийсэн Х.Пэрлээ. УБ., 1960 Асрагч нэртийн түүх /эх бичгийн судалгаа/ галиглаж...хэвлэлд бэлтгэсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2002
5. Занабазарын дөрвөлжин үсэг. хэвлэлд бэлтгэсэн Р.Бямбаа. УБ., 2005
6. Монголын төр эрх зүйн түүх. (дээж бичиг). I, II, III эмхэтгэсэн Б.Баярсайхан УБ., 2006
7. Нангиад монгол "хуа-и и-юй" толь. латин галиг хийж, шинэ үсэгт хөрвүүлсэн С.Жанчив, Ц.Бямбацэнд. УБ., 2005, Ө.Мандах "Монгол И-юй бичиг" Хөх хот., 1995
8. Пэрлээ.Х.Хэсэг байшингийн Монгол бичээс. Монгол судлал. Т III. УБ., 1961
9. Чин улсын дотоод нэрийн бичгийн яамны Монгол данс эвхмэлийн эмхэтгэл. эмхэтгэсэн Чимэддорж ...нар II, III, IV боть. ӨМАХХ. 2004

³⁵ Д.Мөнх-Очир, Ч.Болдбаатар. Манжид үндэсний тусгаар тогтнолоо алдаагүй. "Ардын эрх" сонин

³⁶ Д.Мөнх-Очир, Ч.Болдбаатар. Манжид үндэсний тусгаар тогтнолоо алдаагүй. "Ардын эрх" сонин

³⁷ Мөн тэнд

Түвэд сурвалж.

1. *Дармадаала*. Их Монгол оронд дээдсийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч Цагаан лянхуан эрхис хэмээгдэх оршивой
2. *Сүмбэ хамба Ишбалжир*. Хутагтын эх орон Хятад, Түвэд, Монголын орон дор дээд ном ямар мэт дэлгэрсэн ёсны Галбарвасун модон хэмээгдэх оршивой ӨМАХХ, 2003
3. *Цэмбэлгүүш*. Монголын бурхан шашны түүх. (Монголын түүх оршибай)
4. Л.Тэрбиш, Р.Бямбаа нар түвэд хэлнээс орчуулж тайлбарлав .УБ.,1997
5. Өндөр гэгээний намтарууд оршвой.УБ.,1995
6. *СорхонАгваандондов*.Түгээмэл эзэн, итгэлт Богд тойн Лувсандамбийжалцанбалсамбуугийн сонин хувь төгөлдөр тонилгохыг хүсэгчийн эгээрлийг хангахуй баясгалант хурим нэрт оршивой. түвэд хэлнээс орчуулсан. Д.Цэдэв .УБ.,1995

Судалгааний зохиол

1. *Бира Ш.* Монголчуудын түүх улс төрийн уламжлал дах төрийн дээд эрх мэдлийн тухай сургаал .Түүхийн судлал .Т.Х .F .5 УБ.,1974
2. *Бира Ш.* Монголын түүх ,соёл ,түүх бичлэгийн судалгаа .II .Токио .,1994 ,Монгоын түүх ,соёл ,түүх бичлэгийн судалгаа .III УБ.,2001 ,
3. *Дашбадрах Д.* Занабазар ба Халх-Түвэдийн харилцаа ." Өндөр гэгээн Занабазар " .Эрдэм шинжилгээний бичиг (эмхэтгэл). УБ.,1998
4. *Дашбадрах Д.* V Далай ламаас Монголын анхдугаар Жавзундамба хутагтад соёрхсон соёрлын тухай. Монгол судлал.Сөүл .,1995
5. Монгол улсын түүх .таван боть зохиол. Дөтгөөр боть. УБ.,2004
6. *Нацагдорж Ш.* Халхын түүх. УБ. 1963
7. Нацагдорж Ш. Сум, хамжлага, шавь ард. ШУАХ. УБ.1972
8. Өндөр гэгээн Занабазарын 360 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бичиг. УБ.,1998
9. *Пүрэвжав С.* Монголын шарын шашны хураангуй түүх .УБ.,1978
10. *Ренчин Б.* Соёмба-эмблема свободы независимости монгольского народа ..Из нашего культурного наследия .УБ.,58 .стр.12-16
11. *Санждорж М.* Монгол төрийн түүхээс.УБ., 1998
12. *Хүрэлбаатар Л.* Огторгуйн цагаан гарди .УБ.,1996